



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 06 сарын 05 өдөр

Дугаар 240

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1.а дахь заалт, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Дархан-Уул аймгийн Шарын гол сумын дулааны станцаас дулаан хуваарилах төв хүртэлх гадна дулааны 2.2 км төв шугамын өргөтгөл, шинэчлэлийн ажлын хүрээнд бий болсон нийт 3,888,024,127.00 (гурван тэрбум найман зуун наян найман сая хорин дөрвөн мянга нэг зуун хорин долоон) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг “Дулаан шарын гол” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга З.Мэндсайхан, “Дулаан шарын гол” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Б.Энхцэцэг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Комисс томилон хөрөнгө хүлээн авч бүртгэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА




Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА

0001973

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 06 дугаар сарын 27 -ны өдрийн
А.У.О дугаар тогтоолын хавсралт



**"Дулаан шарын гол" төрийн өмчит хувьцаат компанийн
дансанд бүртгэх барилга байгууламж**

Д/д	Барилга байгууламжийн нэр, байршил	Хөрөнгийн нэр	Барилга		Захиалагч байгууллага	Гүйцэтгэгч байгууллага	Гэрээний дугаар	Улсын комиссын акт дугаар	Төсөвт өртөг (төгрөг)
			Эхэлсэн	Дууссан					
1	"Дулаан шарын гол" ТӨХК-ийн дулааны станцаас дулаан хуваарилах төв хүртэлх гадна дулааны 2.2 км төв шугамын өргөтгөл, шинэчлэлийн ажлын хүрээнд бий болсон барилга байгууламж	Цэвэр усны шугам	2017	2017	ЭХЯ, ЭХХТ	"Бурхант хясаат" ХХК	ЭХХТ/75/ 2017	2017.12.12 46/2017	3,888,024,127.00
	Нийт дүн								3,888,024,127.00 (гурван тэрбум найман зуун наян найман сая хорин дөрвөн мянга нэг зуун хорин долоон)